

18-25 насны оюутнуудын хувь хүний төрөлх өвөрмөц чанарыг мэдээллийн технологид суурилан тодорхойлох нь

Э.Дэлгэрэхзаяа¹, Б.Лодойсамбуу¹, Н.Нямсайхан³, Т.Жаргалмаа³, Х.Цэрэнвандан², С.Доржбат¹, С.Цэндсүрэн¹

¹АШУУИС, МАУОУС, МАУСТЭнхим

²АШУУИС, Био-Анагаахын Сургууль

³АШУУИС, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг

Цахим шуудан: Delgerekhzaaya@mnus.edu.mn, Утас: 80192433

Түлхүүр үг:

Төрөлх өвөрмөц чанар
Уламжлалт анагаах ухаан
Бие бялдар

Товч утга:

Үндэслэл: Хувь хүний махбодын өвөрчлөл, сэтгэхүйн урвалж чанарын онцлогууд нь өөр хоорондоо салшгүй холбоотой бөгөөд тэдгээрийг хамтад нь цогц байдлаар судлах нь зүйтэй юм. Уламжлалт анагаах ухаанд хий, шар, бадганы сургаал нь хүний бие, хэл, сэтгэлийг нэгдмэл тогтолцоонд авч үздэг ба бие махбод эрүүл орших, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх аргыг цогц байдлаар авч үздэг. Мөн нийт суралцаж буй оюутнуудын бие бялдарын үзүүлэлт хоорондын ялгаа биеийн бүрдэл болон хувь хүний төрөлх өвөрмөц чанар хоорондын хамаарал, ачаалал даах чадвар болон сэтгэл зүй хоорондын ялгааг гаргах нь энэхүү судалгааны үндэслэл болно. **Зорилго:** Нийт оюутнуудын хувь хүний төрөлх өвөрмөц чанарыг мэдээллийн технологи ашиглан тодорхойлж бие бялдарын үзүүлэлт хоорондын хамаарлыг тогтоох. **Арга, аргачлал:** Судалгааг харьцангуй эрүүл хүмүүст (харьцангуй эрүүл хүн гэж бие махбод дотоодод нь эмгэг өөрчлөлт орж байгаа боловч тэр нь уг хүний хөдөлмөрийн чадвар, амьдралын идэвхтэй байдлыг алдагдуулахгүй байхыг хэлнэ) эмнэлзүйн ажиглалт болон нэг агшны загвараар хийж гүйцэтгэв. **Үр дүн:** Нийт судалгаанд оролцогсдын насны бүтцийн хувьд 19-25 насны хүмүүс оролцсон бөгөөд дундаж нас 21.5 настай хүмүүс байв. Биеийн өндрийн хувьд хамгийн багадаа 149см, хамгийн өндөр нь 198см дундаж нь 165.7см байна. Биеийн жингийн хувьд хамгийн багадаа 37кг, байсан бол хагийн ихдээ 111кг бөгөөд дундаж жин 61.55 кг байв. БЖИ-ийг харьцаанаас үзэхэд багадаа 15.3, ихдээ, 36.3 дундаж нь 22.36 байна. Судалгаанд оролцогсод хүйсийн хувьд эмэгтэй оюутнууд түлхүү (76.4%) оролцож эрэгтэй (23.6%) оюутнууд нь бага оролцсон байна. Судалгаанд оролцогчдын өвөрмөц чанарыг дийлэнх хоёр махбодоор нь салгаж үзвэл Шар дийлэнх хий хавсарсан өвөрчлөл 21.2%, шар дийлэнх бадган хавсарсан өвөрчлөл 30.8%, хий дийлэнх шар хавсарсан өвөрчлөл 19.6% тус тус эзэлж байв. Стрессийн асуумжийн хувьд хамгийн багадаа 0 оноотой ихдээ 50 оноотой байгаа бөгөөд дундаж нь 20.6 оноотой буюу дунджаас жаахан доогуур сэтгэл зүйн үзүүлэлттэй байгаа хэмээн гарч байгаа юм. Өвөрчлөл болон сэтгэл зүйн асуумж нь хоорондын хамаарал $R=0.323^{**}$ буюу $P=0.001$ буюу эерэг бөгөөд сул хамааралтай байгаа юм. Энэ нь сэтгэл зүйн үзүүлэлт дунджаас доогуур байгаа нь өвөрчлөлөөс маш бага хамааралтай байна. **Дүгнэлт:** Хавсарсан төрөлх өвөрмөц чанартай судалгаанд оролцогчдын аль махбод дийлэнхээс хамаарч биеийн бүрдлийн үзүүлэлттэй шууд болон сөрөг хамааралтай байгаа нь хүн бүрийн биеийн бүрдлийн үзүүлэлт харилцан адилгүй байна. Төрөлх өвөрмөц чанар болон стрессийн төвшин хооронд эерэг бөгөөд сул хамааралтай байгаа нь лавшруулан үзэх шаардлагатай байна.

Үндэслэл: Хувь хүний бие махбодын өвөрчлөл, сэтгэхүйн урвалж чанарын онцлогууд нь өөр хоорондоо салшгүй холбоотой бөгөөд тэдгээрийг хамтад нь цогц байдлаар судлах нь зүйтэй юм. Уламжлалт анагаах ухаанд хий, шар, бадганы сургаал нь хүний бие, хэл, сэтгэлийг нэгдмэл тогтолцоонд авч үздэг ба бие махбод эрүүл орших, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх аргыг цогц байдлаар авч үздэг.¹ Ийм учраас хүнийг өвчлөхөөс өмнө урьдчилан сэргийлэх, өвчнийг бус өвчтөнийг эмчлэх зарчим байх бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэхэд хувь хүний бие махбодын өвөрчлөлийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.² Өнөө үед ДЭМБ (WHO) UNIVERSAL COVERAGE буюу бүх нийтийн эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр бодлого гаргаж түүнийг хэрэгжүүлж ажиллах тал дээр анхаарч байна.³

Уламжлалт анагаах ухаанд бие хүний өвөрмөц байдлыг тодорхойлох аргатай бөгөөд түүнд суурилсан оношилгоо эмчилгээний нэгдмэл систем нь өнөөг хүртэл уламжлагдан ирж хөгжсөөр байна. Энэ чиглэлээр уламжлалт анагаах ухааны хувь хүний өвөрмөц чанар тодорхойлох аргачлалууд байгаа ба энэ чиглэлээр нотолгоонд суурилсан эрдэм шинжилгээний ажлууд мөн хийгдээд байгаа хэдий ч эмнэлзүйн практикт бодит үр дүн гаргах боломж хязгаарлагдмал байна. 21-р зуун бүхэлдээ дижитал орон зайд шилжээд байгаа энэ эрин үед уламжлалт анагаах ухааны зарим боломжит хэрэглэгдэхүүнийг цахим системд нэвтрүүлэх, түүнийг хэрэглээ болох талаас нь уламжлалт анагаах ухааны системтэй орон бүр онцгой анхаарч ажиллаж байгаа юм. Тухайлбал БНХАУ, БНСУ, Энэтхэг, Япон зэрэг улс орнууд өөрсдийн уламжлалт анагаах ухааны хувь хүний өвөрмөц чанарыг тодорхойлох программ зохион бүтээж түүнийг эмнэлэг төдийгүй нийт иргэдийн хүрээнд ашиглуулж түүгээр дамжуулан оношилгоо эмчилгээний зарчим гаргах, хувь хүн бүрд чиглэсэн эмчилгээ хийгдэж цаашлаад өвчнөөс урьдчилан сэргийлэх өргөн боломжуудыг цар хүрээгээр нь бий болгож байгаа нь эмнэлзүйн өндөр ач холбогдолтой юм. Тиймээс энэ чиглэлээр бусад орнуудын туршлагыг судалж Уламжлалт анагаах ухааны хувь хүний өвөрмөц чанар тодорхойлох цахим, дижитал буюу ARTIFICIAL INTELLIGENCE (AI) орон зайг үүсгэж ард иргэдэд чиглэсэн уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг илүү хялбаршуулах, цаашлаад Уламжлалт анагаах ухааны нэгдсэн мэдээллийн системийг бүрдүүлэхэд ач холбогдол оршино.

Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг илүү хялбаршуулах, цаашлаад Уламжлалт анагаах ухааны нэгдсэн мэдээллийн системийг бүрдүүлэхэд ач холбогдол оршино. Мөн нийт суралцаж буй оюутнуудын бие бялдрын үзүүлэлт хоорондын ялгаа биеийн бүрдэл болон хувь хүний төрөлх өвөрмөц чанар хоорондын хамаарал, ачаалал даах чадвар болон сэтгэл зүй хоорондын ялгааг гаргах нь энэхүү судалгааны үндэслэл болов.

Зорилго: Оюутнуудын хувь хүний төрөлх өвөрмөц чанарыг мэдээллийн технологи ашиглан тодорхойлж бие бялдрын үзүүлэлт хоорондын хамаарлыг тогтоох.

Арга, аргачлал: Судалгааг харьцангуй эрүүл хүмүүст (харьцангуй эрүүл хүн гэж бие махбод дотоодод нь эмгэг өөрчлөлт орж байгаа боловч тэр нь уг хүний хөдөлмөрийн чадвар, амьдралын идэвхтэй байдлыг алдагдуулахгүй байхыг хэлнэ) эмнэлзүйн ажиглалт болон нэг агшны загвараар хийж гүйцэтгэв. Оюутнуудын ХХТӨЧ тодорхойлох (Б.Дагвацэрэн, Ө.Батчимэг нарын 2003 боловсруулсан асуумж) мэдээллийн технологид суурилсан тодорхойлсон. Оюутнуудын сэтгэлзүйн байдал үнэлэх оюутнуудын бие бялдар, биеийн бүрдлийн үзүүлэлт, гурван хэмжээст орон зайн дүрслэлийг хувь хүний төрөлх өвөрмөц чанар хоорондын хамаарал харьцуулах. Судалгааг эмнэлзүйн нэг агшингийн аргад түшиглэн харьцангуй эрүүл хүмүүст таниулсан зөвшөөрлийн хуудсыг бөглүүлэн авч бие бялдар, стрессийн төвшинг үнэлсэн. Судалгаанд хамрагдаж буй суралцагчдын хувь хүний төрөлх өвөрмөц чанарыг Монгол уламжлалт анагаах ухааны хүний биеийн өвөрчлөлийн хэв шинжийг Уламжлалт анагаах ухааны шинжлэх ухаан технологийн корпорацын судлаачдын 2003 онд боловсруулсан аргачлалаар тодорхойлов.⁹ Энэ нь АНУ-ын судлаач Robert Sachs-ийн Төвөдийн эмч нартай хамтран 1995 онд боловсруулсан Төвөдийн анагаах ухааны хүний хэв шинж тодорхойлох аргыг боловсронгуй болгон өөрийн нөхцөлд тохируулан сайжруулсан аргазүйн тогтолцоо юм.

Судалгааны өгөгдөхүүнийг SPSS-26 программаар статистик боловсруулалтыг хийхдээ арифметикийн дундаж, стандарт хазайлтыг тодорхойлно. Статистик хамаарлыг нас, хүйс, бие махбодын өвөрчлөл, антропометрийн зарим үзүүлэлтүүдийг хамааруулан гаргаж үнэн магадлалын төвшин, дундаж утгыг үнэлэн тооцоолох аргуудыг хэрэглэсэн. Хувийн Хи квадрат тест, exact test 95%-ийн үнэн магадлалаар гаргасан ба график дүрслэл, хүснэгтийг компьютерын Microsoft Word, Microsoft Excel, гурван хэмжээст орон зайн бие махбодын хэмжилтийн дүрслэлийг Mimics программуудыг ашиглан хийв.

Үр дүн: Нийт судалгаанд оролцогсдын насны бүтцийн хувьд 19-25 насны хүмүүс оролцсон бөгөөд дундаж нас 21.5 жил байв. Биеийн өндрийн хувьд хамгийн багадаа 149 см, хамгийн өндөр нь 198 см дундаж нь 165.7 см байна. Биеийн жингийн хувьд хамгийн багадаа 37 кг, байсан бол хагийн ихдээ 111 кг бөгөөд дундаж жин 61.55 кг байв. БЖИ-ийг харьцаанаас үзэхэд багадаа 15.3, ихдээ, 36.3 дундаж нь 22.36 байна. Судалгаанд оролцогсод хүйсийн хувьд эмэгтэй оюутнууд түлхүү (76.4%) оролцож эрэгтэй (23.6%) оюутнууд нь бага оролцсон байна. Судалгаанд оролцогчдын өвөрмөц чанарыг дийлэнх хоёр махбодоор нь салгаж үзвэл Шар дийлэнх хий хавсарсан өвөрчлөл 21.2%, шар дийлэнх бадган хавсарсан өвөрчлөл 30.8%, хий дийлэнх шар хавсарсан өвөрчлөл 19.6% тус тус эзэлж байв. Стрессийн асуумжийн хувьд хамгийн багадаа 0 оноотой ихдээ 50 оноотой байгаа бөгөөд дундаж нь 20.6 оноотой буюу дунджаас жаахан доогуур сэтгэл зүйн үзүүлэлттэй байгаа хэмээн гарч байгаа юм. Өвөрчлөл болон сэтгэл зүйн асуумж нь хоорондын хамаарал $R=0.323^{**}$ буюу

$P=0.001$ буюу эерэг бөгөөд сул хамааралтай байгаа юм. Энэ нь сэтгэл зүйн үзүүлэлт дунджаас доогуур байгаа нь өвөрчлөлөөс маш бага хамааралтай байна.

Хэлцэмж: Энэ судалгаагаар монгол хүний хувь хүний төрөлх өвөрмөц чанарыг цахим өгөгдөл ашиглан тодорхойлсон нь цаашид иргэд хаанаас ч өөрийн төрөлх өвөрмөц чанарыг тодорхойлох, идээ ундаа, дасгал хөдөлгөөн, цаг, улиралтай тохируулан хувцаслах зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг, заавар зөвлөгөө хялбар авах боломжийг бүрдүүлэх суурь судалгаа юм. Дорно дахины эртний Энэтхэгт үүсэж бий болсон Аюурведын анагаах ухаан нь НТӨ 6000 жилийн өмнөөс үүсэлтэй бөгөөд хүний биеийн махбодын өвөрчлөлийг Vata, Pitta, Kapha гэсэн 3 dosha дан дангаар 3 хавсарсан 3 гурвуул хурсан нэг нийт 7 өвөрчлөлд хувааж үздэг. Энэ хамгийн анхны цэгцтэй онол бөгөөд өнөө бидний үед уламжлагдан баяжиж ирсэн байна.²⁸ Түүнчлэн эртний Хятадын анагаах ухаанд Инь-Янгийн онолд тулгуурласан таван махбодын сургаал нь орчлон, ертөнцийн гарал үүслийг шороо, ус, гал, хий гэх анхдагч элементүүдийн үүсэл хөгжлийн үр дүнд бий болсон гэж нотолсон онол юм. Хий, шар, бадганыг одон зурхайд 5 махбодод төлөөлүүлэн авч үздэг.²⁹ Шороо+усан махбодуудыг нийлүүлэн бадган, гал махбодыг шараар, хий махбодыг хийгээр төлөөлүүлэх ба огторгуй махбодын мөн чанарыг нийгэд нь түгэн оршиж байгаа гэж үздэг. Хүн эхээс төрөхдөө таван махбодын аль нэг нь давамгайлсан байх ба зөвхөн тэр махбодод заяасан өөрийн өвөрмөц өвөрчлөлтэй төрдөг хэмээн бичсэн байдаг бол ертөнц дээр адилхан хүн байдаггүй бөгөөд тэдгээрийн зан араншин, үзэл бодол, таашаал, цул, сав эрхтний бүтэц, өвчлөх байдал, хоол унд, эмийн бодисын үйлдлийг мэдрэх чадвар, эрс өөр байдаг гэж үздэг бөгөөд энэ дагуу нэг хүн-нэг эмчилгээ гэсэн зарчмыг Ин-Янгийн онолтой шүтэлцүүлэн гаргасан байдаг байна. Эдгээр уламжлалт тайлбар зохиолуудын мөн чанар харилцан үл зохилдовч тэдгээр нь биеийн шар усны нүхэнд хүртэл хамт оршиж үйл үйлдэх бөгөөд эдгээрийн үйл үгүй бол бие үгүй хэмээн тодорхойлдог. Хий, шар, бадган харилцан бие биедээ түшиглэн биеийн бүхий л хэсэгт энэ тэнцүү оршиж эрдэм чадал, үйлдлээ үзүүлдэг байна гэсэнтэй дүйж байна.

Түүнчлэн судлаач Б.Цэрэнцоо нарын (2010) оны судалгаанд уламжлалт анагаах ухааны бие махбодын өвөрчлөлийг антропометрийн хэмжилт болон сэтгэл судлалын зарим аргаар харьцуулан 18-79 насны харьцангуй эрүүл хүнд явуулсан судалгаагаар уламжлалт анагаах ухааны хүний биеийн төрөлх өвөрмөц чанартан судлахад хий шар, шар хий хавсарсан өвөрчлөлтэй хүмүүс 40.8%, шар бадган, бадган шар хавсарсан өвөрчлөлтэй хүн 46.4%, хий бадган, бадган хий хавсарсан өвөрчлөлтэй хүн 10.8% тохиолдсонтой харьцуулан авч үзвэл бидний судалгаанд хамрагсдын түүврийн хэмжээ, хүйсээс хамаарч тархалт болон хавсарсан өвөрчлөл ялгаатай гарсан байж болох юм. Бидний судалгаанд шар, хий хавсарсан хүмүүс дийлэнх байсан бөгөөд шар хий хавсарсан хүмүүст стрессийн түвшин хамгийн их байсан нь бидний судалгаатай дүйж байна.

Судлаач Б.Цэрэнцоо (2010) нарын судалгаанд стрессийн түвшинг авч үзэхэд хий дийлэнх байх тусам стрессийн түвшин нэмэгдэх хандлагатай байсан нь Бидний судалгаанд хамрагсдын 30.6.% нь маш хүнд стресстэй гарсан үүнийг өвөрчлөлтэй холбоод үзвэл шар дийлэнх хий хавсарсан өвөрчлөлтэй хүмүүс эзэлж байсан нь дүйж байна. Б.Цэрэнцоо нарын судалгаанд хий дийлэнх байх тусам сэтгэл хөдлөл ихтэй стрессийн түвшин өндөр байх хандлагатай, бадган дийлэнх байх тусам тайван дөлгөөн зантай сэтгэл хөдлөл багатай байгаа нь бидний судалгааны бэлгэ чанарын үүднээс үзсэнтэй дүйж байна. Бэлгэ чанар нь тухайн хүний мөн чанарыг илтгэхээс гадна зан төрхийг давхар илтгэдэг. Хий дийлэнх өвөрмөц чанартан нь хөнгөн, хөлбөрөнги бэлгэ чанараас шалтгаалж олон ааштай, сэтгэл санаа тогтворгүй сэтгэл хөдлөл ихтэй. Сэтгэлийн хөдөлгөөний илрэл нь хэлээр дамжин илэрч байдаг. Харамч дээрэнгүй зантай байх хандлагатай, оюуны хувьд амархан сурч амархан мартдаг хандлагатай. Шар дийлэнх өвөрмөц чанартан нь халуун хурц бэлгэ чанараас хамаарч сэтгэл санаа тогтвортой, шударга, уур омог, хор шар ихтэй ухаан хурц, үг яриа тод илэрдэг оюуны хувьд ойлгоц сайтай байна. Бадган дийлэнх өвөрмөц чанартан нь батлаг, наалдамхай, зөөлөн бэлгэ чанартай холбоотойгоор тэвчээртэй тайван дөлгөөн зөөлөн сэтгэлтэй, муу сэтгэлгүй бусдад туслах сэтгэлтэй хүн юм. Хөдөлгөөн багатай, аливаа асуудалд нухацтай ханддаг ойлгоц удаан ойлгож, удаан мартана.

Дүгнэлт: Хавсарсан төрөлх өвөрмөц чанартай судалгаанд оролцогчдын аль махбод дийлэнхээс хамаарч биеийн бүрдлийн үзүүлэлттэй шууд болон сөрөг хамааралтай байгаа нь хүн бүрийн биеийн бүрдлийн үзүүлэлт харилцан адилгүй байна. Төрөлх өвөрмөц чанар болон стрессийн төвшин хооронд эерэг бөгөөд сул хамааралтай байгаа нь лавшруулан үзэх шаардлагатай байна.

Ном зүй:

1. Б.Цэрэнцоо. Уламжлалт анагаах ухааны бие махбодын өвөрчлөлийг антропометрийн хэмжилт болон сэтгэл судлалын зарим аргаар харьцуулан судлах асуудал. Улаанбаатар: Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль; 2010.
2. Анагаах Ухааны Дөрвөн Үндэс. Улаанбаатар 1991.
3. Ш.Болд. Монголын уламжлалт анагаах ухаан: гүн ухаан онол, эрүүл биеийн судлал. Улаанбаатар 2012.
4. Grant SJ, Lipe B. Management of frail older adults with newly diagnosed multiple myeloma—moving toward a personalized approach. *Clinical Lymphoma Myeloma and Leukemia*. 2020;20:S76-S80.
5. Caballero B. Humans against obesity: who will win? *Advances in nutrition*. 2019;10:S4-S9.
6. Guilbert J. The World Health Report 1998—Life in the 21st Century. A Vision for All. *Education for Health*. 1999;12(3):391.
7. Fryar CD, Gu Q, Ogden CL. Anthropometric reference data for children and adults; United States, 2007-2010. 2012.
8. Д.Цэрэндаваа СС. Монгол анагаах ухааны өвчнийг шинжилж нотлохуйн нэгдмэл толь Улаанбаатар 2023.
9. རྩམ་སྐད་ཐོག་མའི་སྐད་ཀྱི་ལྟོ་སྐབས་འཕེལ་འགྱུར་གྱི་ཁྱད་པར་
10. Stevens GA, Singh GM, Lu Y, et al. National, regional, and global trends in adult overweight and obesity prevalences. *Population health metrics*. 2012;10:1-16.
11. Алтан хадмал.

The identification of Unique Personal Characteristicsv and Body Constitution of Students Aged 18-25 Utilizing Information Technology

Delgerekhzaya E¹, Lodoisambuu B¹, Nyamsaikhan N³, Jargalmaa T³, Tserenvandan Kh², Dorjbat S¹, Tsendsuren S¹

¹Department of Mongolian medicine study, International School of Mongolian Medicine, MNUMS

²School of Biomedicine, MNUMS

³Central Hospital of Mongolian Medicine, MNUMS

E-mail :Delgerekhzaya@mnum.s.edu.mn, Tel: +976-80192433

Background: The physiology and intellectual traits of individuals are interrelated and should be studied comprehensively. In traditional medicine, the teachings of wind (khi), bile (shar), and phlegm (badgan) are considered an integrated system for maintaining health, preventing diseases, diagnosing, and treating illnesses.

Aim: Our research is to study students' physical indicators, body composition, innate characteristics and the relationship between physique and psychological factors.

Materials and Methods: The study was conducted on relatively healthy individuals, did clinical observations and used a cross-sectional study design. (defined as those experiencing internal physiological changes that do not impair their work capacity or active lifestyle)

Results: Participants were aged 19-25 years, with an average age of 21.5. Heights ranged from 149 cm to 198 cm, with an average of 165.7 cm. Weights ranged from 37 kg to 111 kg, with an average of 61.55 kg. The Body Mass Index (BMI) varied between 15.3 and 36.3, with an average of 22.36. The majority of participants were female (76.4%), while male participants accounted for 23.6%. Regarding individual constitutional types, the most common were: predominantly bile with wind characteristics (21.2%), predominantly bile with phlegm characteristics (30.8%), predominantly wind with bile characteristics (19.6%). Stress survey results ranged from a minimum score of 0 to a maximum of 50, with an average score of 20.6, indicating slightly below-average psychological well-being. The correlation between physiological traits and psychological survey scores was $R=0.323^{**}$ ($p=0.001$), showing a weak but positive correlation. This suggests that below-average psychological well-being is only minimally influenced by physiological traits.

Conclusion: The stress survey results indicated an average score of 20.6, slightly below the normal psychological index. The correlation between constitutional traits and psychological well-being was weak but positive ($R=0.323^{**}$, $p=0.001$). This implies that individual constitutional characteristics have a minimal effect on psychological well-being. In the study of intrinsic unique characteristics, it has been found that certain physical constitution metrics of the participants demonstrate both positive and negative correlations with the majority of body types, indicating that individuals exhibit varying physical constitution characteristics. Additionally, there exists a positive but weak correlation between intrinsic unique characteristics and stress levels, warranting further investigation.

Keywords: Body constitution, Traditional medicine, Physical traits